



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

“Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах
төсөл” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 12 дугаар тогтоолын 2.1.6 дахь хэсгийг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, архи болон мансууруулах бодис түүний хэрэглээнээс урьдчилан сэргийлэх “Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах төсөл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шаардагдах төсвийг жил бүр, цаг үеийн нөхцөл байдал, судалгаатай уялдуулан төлөвлөн, баталж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Ц.Баттөр)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо (Х.Эрдэнэтуяа)-нд даалгасугай.

ДАРГА  БЗОЛБОО



1825030010

Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралт




СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ДЭМЖИХ ТӨСӨЛ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2019 онд Эрүүл мэндийн яам, Анагаахын Шинжлэх ухааны Үндэсний их сургууль, Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад байгууллага хамтран “Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт”-ын судалгааг Улаанбаатар хотын төвийн 3, алслагдсан 2 нийт 5 дүүрэг, хөдөө орон нутгаас 11 аймгийн нийт 53 сумыг хамруулан зохион байгуулсан. Энэхүү судалгаагаар Монгол улсын зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалтыг тогтоох зорилгоор 11 аймаг, 53 сум, хотын 5 дүүргийн 18-64 насны эрэгтэй 5768 (49.1%), эмэгтэй 5978 (50.8%) нийт 11746 хүнийг судалгаанд хамруулахад сэтгэл түгших эмгэг 18.4% (n=2163), органик бус нойрны эмгэг 17.5% (n=2059), архаг ядаргаа 16.2% (n=1908), тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 11.9% (n=1403), архинд донтох эмгэг 6.4% (n=753), сэтгэл гутрах эмгэг 6.2% (n=734)-ийн тархалттай байлаа (Зураг 11). Өөрөөр хэлбэл 18-64 насны хүмүүсийн дунд ойролцоогоор 5 хүн тутмын 1 нь сэтгэл түгших эмгэгтэй, 5-6 хүн тутмын 1 нь органик бус нойрны эмгэгтэй, 6 хүн тутмын 1 нь архаг ядаргаатай, 8 хүн тутмын 1 нь тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа эмгэгтэй, 15-16 хүн тутмын 1 нь архинд донтох эмгэгтэй, 16 хүн тутмын 1 нь сэтгэл гутрах эмгэгтэй байх магадлалтай байна.

18-64 насныхны дунд зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгүүдийг сэтгэл түгших эмгэг (18.4%, n=2163), органик бус нойрны эмгэг (17.5%, n=2059) архаг ядаргаа (16.2%, n=1908) зэрэг эмгэгүүд тэргүүлж байна.

Судалгаанд хамрагдсан нийслэлийн 5 дүүргийн харьцуулалт:



● Ногоон: Органик бус нойрны эмгэг

- Цэнхэр: Сэтгэл гутрал
Шар: Тайлбарлаж болмооргүй биеийн зовуур шаналгаа
- Саарал: Сэтгэл түгших эмгэг
- Улаан: Архаг ядаргаа
- Ягаан: Архинд донтох эмгэг.

Судалгаагаар Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргүүд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгээрээ бусад аймаг дүүргүүдийг тэргүүлж байна.

Тухайлбал: Баянзүрх дүүрэгт сэтгэл гутрах эмгэг 21.0%, архаг ядаргаа 17.6%, тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 16.5%, сэтгэл түгших эмгэг 16.5%, органик бус нойрны эмгэг 15.3%, архинд донтох эмгэг 13.8%-ийн тархалтуудтай байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт органик бус нойрны эмгэг 15.3%, архаг ядаргаа 15%, сэтгэл түгших эмгэг 14.7%, сэтгэл гутрах эмгэг эмгэг 14.2%, тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 13.2%, архинд донтох эмгэг 7.2%-ийн тархалттай байна. Судалгаанаас дараах дүгнэлтийг гаргасан байна.

1. Монгол улсын 18-64 насныхны дунд сэтгэл түгших эмгэг 18.4% (n=2163), органик бус нойрны эмгэг 17.5% (n=2059), архаг ядаргаа 16.2% (n=1908), тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 11.9% (n=1403), архинд донтох эмгэг 6.4% (n=753), сэтгэл гутрах эмгэг 6.2%, (n=743) хувийн тархалттай байв. Зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгүүдийг сэтгэл түгших эмгэг (18.4%, n=2163), органик бус нойрны эмгэг (17.5%, n=2059), архаг ядаргаа (16.2%, n=1908) зэрэг эмгэгүүд тэргүүлж байна.

2. 18-64 насны 1000 хүн амд ноогдох байдлаар шилжүүлж судлахад сэтгэл түгших эмгэг 184.1, органик бус нойрны эмгэг 175.3, архаг ядаргаа 162.4, тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 119.4, архинд донтох эмгэг 64.1, сэтгэл гутрах эмгэг 62.5 байв. 1000 хүн амд ноогдох тохиолдлын тоогоороо хөдөө орон нутгаас Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Булган зэрэг аймгууд тэргүүлж байгаа бол Улаанбаатар хот нь стрессийн гаралтай зонхилон тохиолдох эмгэгээр тэргүүлэх хандлагатай байв.

3. Зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгүүдийн тархалтаараа Улаанбаатар хотын Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргүүд 10-аас дээш хувиар бусад аймаг дүүргүүдийг тэргүүлсэн. Аймгуудын хувьд зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалтын хамгийн өндөр нь 10 орчим хувьтай байна.

4. Зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгүүд нь ид ажил хөдөлмөр эрхэлж идэвхтэй амьдрах насанд буюу 35-39 нас, 40-49 нас, 50-54 насны бүлгүүдэд хамгийн их тохиолдож байлаа. Архинд донтох, сэтгэл гутрах эмгэгүүд нь 35-54 хүртэл, тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа (16.6%), сэтгэл түгших эмгэг (16.7%), органик бус нойрны эмгэг (15.5%) зэрэг эмгэгүүд нь 50-54 насанд Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт 10,0 Судлаач Murcia M2, Chastang JF, NiedhammerL нарын 2015 онд Франц улсын үндэсний хэмжээнд 11,777 хүн хамруулж хийгдсэн судалгааны үр дүнд ажилгүй хүмүүсийн дунд сэтгэл гутрах, сэтгэл түгших эмгэг нь илүү тохиолдож байгаа нь батлагдсан бөгөөд ажилгүй, боловсрол багатай хүмүүсийн 23-28% нь сэтгэл гутрал, 23-37% нь сэтгэл түгших эмгэгтэй байжээ.

2011 онд ДЭМБ-аас сэтгэл гутрах эмгэгийн тархалтыг тогтоох зорилготой 18 улсын насанд хүрсэн 89037 хүнийг хамруулсан судалгаагаар хүнд сэтгэл гутрах тохиоллын насан туршийн дундаж тархалт өндөр орлоготой 10 оронд 14.6%, сүүлийн

12 сарын дундаж тархалт 5.5% ба багаас дунд орлоготой 8 оронд 11.1%, 5.9% байна. Эмэгтэй эрэгтэй хүйсийн харьцаа ойролцоогоор 2:1 байсан. Монгол орны сэтгэл гутрах эмгэгийн тархалт (6.2%)-ыг ДЭМБ-аас хийсэн судалгааны сүүлийн 12 сарын дундаж тархалттай харьцуулахад өндөр орлоготой 10 орнуудаас 0.7%-иар, бага болон дунд орлоготой 8 орнуудаас 0.3%-иар тус тус өндөр байгаа нь олон улсын дундажтай манай улсын сэтгэл гутрах эмгэгийн тархалт ялимгүй их хувьтай байв.

“Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх” судалгааг 2024 онд Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран хийсэн байна. Энэхүү судалгаагаар:

Амиа хорлолт нь нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болсоор байгаа бөгөөд (ДЭМБ, 2021) өсвөр насныхны нас баралтын тэргүүлэх шалтгааны 4 дүгээрт амиа хорлолт орж, амиа хорлолтын нийт тохиолдлын 77% нь хөгжиж буй болон ядуу буурай орнуудад бүртгэгдэж байна.

Монгол улсын хувьд 2021 оны байдлаар, 100000 хүн амд ноогдох амиа хорлож нас барсан дундаж тохиолдлын тоо 15.0 байгаа нь дэлхийн дунджаас (10.6), 4.4-өөр, бүсийн дунджаас (10.2) 4.8-аар илүү байгаа нь Номхон далайн Баруун эргийн бүсийн хэмжээнд 5 дугаарт орж буй үзүүлэлт болж байна. Манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 16.9 мянган хүн нас барснаас 2.8% орчим нь амиа хорлож нас баржээ. 2010-2019 оны дунджаар нийт нас барсан хүн амын 60.5%, амиа хорлож нас барсан тохиолдлын 85% нь эрэгтэй хүйсийнх байв. Монгол улсын Эрүүл мэндийн үзүүлэлт 2021 оноос үзвэл 2021 онд 483 хүн амиа хорлож нас барсан ба энэхүү үзүүлэлтийг 10 000 хүн амд харьцуулахад 1.5 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 19, 2020 онтой харьцуулахад 32 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. ДЭМБ-ын тайланд нийт 103 улс оронд хийсэн судалгаанаас харахад 11.9% нь архинд донтох эмгэгтэй байна. Үүнээс харахад архи, мансууруулах хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн эзлэх хувь жилээс жилд ихсэж байгаа боловч эмчилгээ үйлчилгээнд хамрагдах байдал нь хангалтгүй байсаар байна гэжээ. Манай улсад ДЭМБ-ын санхүүжилтээр хийсэн судалгаагаар дэгдэмхий уусгагч бодисын хэрэглээ 5.3% байсан ба сэтгэц идэвхт бодисын хэрэглээ 22% (33) байгаагаас каннабис (8.7%), харин тайвшруулах, нойрсуулах эм (8%) зонхилж байна. Мөн ЕБС-ийн 9, 10-р ангийн 1000 сурагчдын дунд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 9% нь мансууруулах бодис хэрэглэж байсан. СЭМҮТ-ийн 2013 оны Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаагаар архинд донтох эмгэг 6.2% байсан бөгөөд 1986-1992 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад архинд донтох эмгэг 40 дахин ихэссэн байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал дэлхий даяар эрчимтэй өсөж байгаа бөгөөд энэ нь манай оронд ч адилхан үзэгдэл болж байна. Ялангуяа ковид-19-ийн дараах сэтгэцийн эрүүл мэндийн хүндрэл, сэтгэл гутрал, сэтгэцийн эмгэгүүдийн тархалт нэмэгдсэн. Сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгүүд нь хүний өдөр тутмын амьдралд, гэр бүл, ажлын орчинд ихээхэн нөлөө үзүүлж, нийгэмд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд энэхүү төслийг хэрэгжүүлэхээр боловсрууллаа.

ХОЁР.ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, архи болон мансууруулах бодис түүний хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа өсвөр насныхан, залуучуудад чиглэсэн сэтгэлзүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, амиа хорлолтыг бууруулахад оршино.

ГУРАВ.ТӨСЛИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

3.1.Зорилго 1

Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, эмгэг, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, интернет хэрэглээний хэтрүүлэг, цахим дарамт, үе тэнгийн дээрэлхэлттэй тэмцэх замаар сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах.

3.1.1.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1.1.Өсвөр насныханд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, сэтгэцийн эмгэгүүдийн талаар мэдээлэл өгч, зөв ойлголт бий болгох, сэтгэцийн эмгэгүүдийг тодорхойлох, стрессийг удирдах, өөрийнхөө мэдрэмжийг ойлгох үр чадваруудад сургах;

3.1.1.2.Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн талаар судалгаа хийж, үр дүнг тооцох, танилцуулах, хамгийн үр дүнтэй аргуудыг тодорхойлох;

3.1.1.3.Их, дээд, ерөнхий боловсролын сургуулиудад сэтгэл зүйн кабинетуудыг бий болгох, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах.

3.1.2.Хүрэх үр дүн:

3.1.2.1.Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн ойлголт хандлага нэмэгдэж, өөрийн стресс, бухимдлыг удирдах үр чадварт суралцсан, сэтгэцийн эмгэгээс үүдэлтэй өвчлөл, эндэгдэл буурсан байна.

3.1.2.2.Сэтгэл зүйн кабинет нэмэгдсэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудын үр чадвар ахисан, зөвлөгөө, мэдээлэл авах өсвөр насныхны тоо нэмэгдсэн байна.

3.2.Зорилго 2

Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангах, ажлын стресс, бухимдлыг даван туулах сэтгэл зүйн үйлчилгээг нэмэгдүүлэх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сэтгэл зүйч ажиллуулах, "Хамт олонтой дэмжих үйлчилгээ"-г бий болгох.

3.2.1.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1.1.Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хаагчдад зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

3.2.1.2.Эрүүл мэндийн байгууллагын сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, хүний нөөцөөр хангах;

3.2.1.3.Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд "Хамт олонтой дэмжих үйлчилгээ"-г нэвтрүүлэх, турших, "Нийгмийн туслалцаа, зөвлөгөө өгөх төв"-ийг байгуулах.

3.2.2.Хүрэх үр дүн:

3.2.2.1.Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд илүү ач холбогдол өгч, нийгэмд сэтгэцийн эрүүл мэндийн талаар зөв ойлголт бий болно.

3.2.2.2.Сэтгэцийн эмгэгүүдийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн, өвчлөл буурсан байна.

3.2.2.3.Хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ нь хүмүүсийг сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд илүү нээлттэй, тусламж авах боломжтой болно.

3.2.2.4.Сэтгэцийн эрүүл мэндийн хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээ өргөжсөн байна.

3.3. Зорилго 3

Сэтгэцэд нөлөөлөх архи, тамхи, мансууруулах бодис, эмийн хэрэглээний хэтрүүлэг болон донтох эмгэгийг эрт илрүүлж, шаардлагатай эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн, нийгмийн дэмжлэгийг үзүүлж, өвчлөл, эндэгдлийг бууруулах.

3.3.1.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1.1.Сэтгэцэд нөлөөлөх архи, тамхи, мансууруулах бодис, эмийн хэрэглээний талаарх судалгаа, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;

3.3.1.2.Архи хэтрүүлэн хэрэглэдэг, донтох эмгэгтэй хүмүүст чиглэсэн тусгай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.3.1.3.Архины болон тамхины хэрэглээний сөрөг нөлөөний талаар нийгмийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх богино хэмжээний цахим хичээл, видео контентуудыг хийх, олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлах;

3.3.1.4.Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгүүдэд “Неврозын тасаг” байгуулах ажлыг эхлүүлэх, хүний нөөцийг бэлтгэх.

3.3.2. Хүрэх үр дүн:

3.3.2.1.Сэтгэцэд нөлөөлөх архи, тамхи, мансууруулах бодис болон эмийн хэрэглээний сөрөг нөлөөний талаар нийгмийн мэдлэг, ойлголт нэмэгдэнэ.

3.3.2.2.Архинд донтох эмгэгийн эрт илрүүлэлт болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулах нь өвчнийг илрүүлэх хугацааг багасаж, эмчилгээг хурдан эхлүүлэх боломжийг бий болсон байна.

3.3.2.3.Эрүүл мэндийн зардал багасаж, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал буурах, нийгмийн амьдралын чанар сайжрах эерэг үр дагавар гарсан байна.

ДӨРӨВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Төслийг 2025-2028 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. 1 дүгээр үе шатыг 2025-2026 онд хэрэгжүүлэх ба “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Алсын хараа 2050”, улс, нийслэлээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төслүүдтэй уялдуулна. 2 дугаар үе шатыг 2027-2028 онд өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд суурилсан, онцлог хэрэгцээ, шаардлагыг тооцон, төлөвлөлтийг өөрчлөн хуулийн хэрэгжилттэй уялдуулан хэрэгжүүлнэ.

ТАВ.ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

5.1.Төслийн зардлыг бүрэн тооцож, жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1.Орон нутгийн төсөв;

5.1.2.Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр;

5.1.3.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4.Бусад эх үүсвэр.

ЗУРГАА.ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

6.1.Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх;

6.2.Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;

6.3.Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх;

6.4.Дүүргийн хүн ам, нийгэм, эдийн засгийн байдал, орчны нөхцөл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээ онцлогийг харгалзсан байх.



ДОЛОО.ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1.Дүүргийн засаг даргын тамгын газар

7.1.1.Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

7.1.2.Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг жил бүрийн дүүргийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.3.Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын зөвлөлд, жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл, Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо, хуралдаанд тайлагнах;

7.1.4.Байгууллага хоорондын уялдаа холбоог хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

7.2.Дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг

7.2.1.Эрүүл мэндийн төв нь өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.2.2.Сэтгэцийн кабинетын үйл ажиллагааг тогтмолжуулах;

7.2.3.Сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дахь сургалтыг тасралтгүй явуулах;

7.2.4.Сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгааг мэргэжлийн дээд шатны байгууллагатай хамтран зохион байгуулж, дүгнэлтэд үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөх;

7.2.5.Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах.

7.3.Өрхийн эрүүл мэндийн төв, хорооны Засаг дарга

7.3.1.Хорооны Засаг даргатай хамтран хүн амын бүртгэлийг насны бүлэг, хүйсийн ангиллаар гаргах, зорилтот бүлэг, насны иргэдийн болон түр оршин суугч иргэн, оюутны мэдээлэл судалгааг жил бүр шинэчлэх;

7.3.2.Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, зөв дадлыг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага, төр, төрийн бус байгууллагатай хамтран тогтмол олон хэлбэрээр зохион байгуулах;

7.3.3.Эрсдэлт бүлгийн болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрүүлжүүлэх;

7.3.4.Нөхөн үржихүйн насны хүн амын дундах зонхилон тохиолдох өвчлөлийн тандалт, судалгааг зохион байгуулж, хариу арга хэмжээг төлөвлөх;

7.3.5.Нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

7.3.6.Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвд тайлагнах.

7.4.Иргэд, Аж ахуйн нэгж, Байгууллага

7.4.1.Хороо, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс болон бусад эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулж буй эрүүл мэндийн үйл ажиллагаа, сургалт сурталчилгаанд идэвхтэй оролцох;

7.4.2.Иргэд жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

7.4.3.Байгууллагууд албан хаагчдаа жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах;

7.4.4.Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх арга хэмжээг үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран тогтмол явуулах;

7.4.5.Байгууллага бүр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт ажилтнуудад чиглэсэн эрүүл мэндийн арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангах;

7.4.6.50 ба түүнээс дээш ажилтантай байгууллага бүр эмч, сэтгэл зүйчийг хуулийн дагуу ажиллуулах, өрөө тасалгааг тохижуулах;

7.4.7.Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах.

НАЙМ.ТӨСЛИЙН ШАЛГУУР

8.1.Сэтгэцийн эрүүл мэндийн талаар мэдээлэл авсан хүмүүсийн тоо;

8.2.Эмчилгээ, үйлчилгээ авах хүсэлт гаргасан иргэдийн тоо;

8.3.Нийгэм, иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн талаарх сөрөг ойлголт буурсан тоо;

8.4.Хамт олны дэмжлэгтэйгээр сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн тоо;

8.5.Төсөл нь нийгмийн сайн сайхны төлөө, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоо хангасан, нийгмийн бүх давхаргад хүртээмжтэй хүрсэн тоо.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх
төсөл” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 12 дугаар тогтоолын 2.1.6 дахь хэсгийг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, эрүүлжилтийг нэмэгдүүлэх, тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тархалт, өвчлөлийг бууруулах “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шаардагдах төсвийг жил бүр, цаг үеийн нөхцөл байдал, судалгаатай уялдуулан төлөвлөн, баталж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Ц.Баттөр)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо (Х.Эрдэнэтуяа)-нд даалгасугай.

ДАРГА



Б.ЗОЛБОО

1825030012

Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны
өдрийн 28 дугаар тогтоолын хавсралт



ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж заасан бөгөөд энэ хүрээнд Улсын Их Хурлаас хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн холбогдох хууль, тогтоомжийг баталсан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас халдварт өвчинтэй тэмцэх чиглэлээр дараах бодлогын баримт бичигт тусгагдсан байна.

1. “Төрөөс эрүүл мэндийн талаарх баримтлах бодлого 2017-2026” бодлогын бичигт шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх хэмээн тусгасан байна;

2. “Алсын хараа 2050” бодлогын бичиг баримт бичиг Хүний хөгжлийн хэсэг буюу “Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих” хэсэгт эрүүл мэндийн үндсэн 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

“Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.” гэж зорьсон.

Зорилтын хүрээнд 2021-2025 онд “Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10,000 хүн амд тохиолдох вируст гепатитийн өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 хувь болгон бууруулахаар төлөвлөсөн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дох хэсэг Хүний хөгжлийн бодлогын 2.2-т “Эрүүл монгол хүн” арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

-Иргэдээ эрүүл, урт наслахад чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт технологийг цогцоор нэвтрүүлж, иргэн эх орондоо оношлогдож, эмчлэгдэх боломжийг нэмэгдүүлнэ.

-“Эрүүл шүд”, “Хорт хавдраас сэргийлэх, хянах”, “Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх “Эрүүл Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ гэж тусгасан байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/523 дугаар тушаалаар “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө” батлагдсан.

Улс, нийслэлийн хэмжээнд дэвшүүлж буй зорилтыг хэрэгжүүлэх, хүн амын дунд халдварт өвчний тархалт буурахгүй, шинэ хэлбэрийн халдварт цар тахлын өвчлөл нэмэгдэж байгаатай уялдуулан олон нийтийг хамарсан урьдчилан сэргийлэх

арга хэмжээ, эрүүл мэндийн үзлэг, оношлогоог орон нутагт зохион байгуулж хүн амын дунд далд оношлогдохгүй байгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүүл мэндийн боловсрол олгож, хандлагыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулах шаардлагатай тул төслийг шинэчлэн боловсрууллаа.

ХОЁР.ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх үйл ажиллагаанд төр болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, халдварт өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар халдварт өвчний тархалтыг бууруулахад оршино.

ГУРАВ.ТӨСЛИЙН ЗОРИЛТ

3.1.Зорилт 1

Дархлаажуулалт бүхий (тарилгаар сэргийлэгддэг) халдварт өвчний тандалтыг эрчимжүүлэх, дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдол, эндэгдлийг бууруулна.

3.1.1.Үйл ажиллагаа:

3.1.1.1.Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, хамралтыг мэдээлэх цахим бүртгэлийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;

3.1.1.2.Дархлаажуулалтын талаарх иргэдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх, сургалт, зөвлөгөөг тогтмол зохион байгуулах;

3.1.1.3.Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт өвчний төвшинг тогтоох, судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, судлаач эмч бэлтгэх;

3.1.2.Үр дүн: Халдварт өвчний тандалтыг эрчимжүүлснээр илрүүлэлт нэмэгдэж, дархлаажуулалтын талаарх иргэдийн мэдлэг, хандлага сайжирч, товллын хамралт нэмэгдсэн байна.

3.2.Зорилт 2

Хепатитийн вируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдварыг эрт илрүүлэх, хүн амын дундах вирусийн халдварын тархалтыг хязгаарлаж, өвчлөл, нас баралтыг бууруулна.

3.2.1.Үйл ажиллагаа:

3.2.1.2.Хепатитийн вируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх арга хэмжээг зорилтот бүлгийн хүн ам болон зорилтот насны хүн амын дунд тогтмол зохион байгуулах;

3.2.1.3.Хепатитийн А, В вируст халдварын эсрэг дархлаажуулалтыг өргөжүүлэх, халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх;

3.2.2.Үр дүн: Хепатитийн вируст халдварын эрт илрүүлгийн хувь нэмэгдэж, элэгний төрөл бүрийн өвчлөл, хавдар буурна.

3.3.Зорилт 3

БЗДХ/ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа хийх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн цогц, чанартай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж халдварын тархалтыг бууруулна.



3.3.1. Үйл ажиллагаа:

3.3.1.1. БЗДХ, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, цахим бүртгэл бүхий сургалт мэдээллийн төв байгуулах;

3.3.1.2. Нөхөн үржихүйн насны, бэлгийн идэвхтэй амьдралтай хүн амыг болон эрсдэлт бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, нууцлалыг ханган эрүүлжүүлэх;

3.3.1.3. Охидын эмч, нөхөн үржихүйн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургаж дадлагажуулах.

3.3.2. Үр дүн: БЗДХ-ын талаарх иргэдийн мэдлэг сайжирч, хандлага өөрчлөгдсөнөөр өвчлөл буурч, эрт илрүүлэг, эмчилгээний хувь нэмэгдсэн байна.

ДӨРӨВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

4.1. Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх;

4.2. Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;

4.3. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх;

4.4. Дүүргийн хүн ам, нийгэм, эдийн засгийн байдал, орчны нөхцөл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээ онцлогийг харгалзсан байх.



ТАВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Дүүргийн “Халдварт бус өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл”-ийг 2025-2028 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

ЗУРГАА.ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. Дүүргийн Засаг даргын Тамгын газар

6.1.1. Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

6.1.2. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг жил бүрийн дүүргийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.3. Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын зөвлөлд, жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл, Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо, хуралдаанд тайлагнах;

6.1.4. Байгууллага хоорондын уялдаа холбоог хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

6.2. Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг

6.2.1. Эрүүл мэндийн төв нь өрхийн Эрүүл мэндийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

6.2.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дахь сургалтыг тасралтгүй явуулах;

6.2.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, цахим бүртгэлийн сантай болгож, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг холбогдох дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

6.2.4.Халдварт өвчний тохиолдлын дүгнэлтийг тухай бүрд хийж, алдаа зөрчлийг илрүүлэн засаж, нарийн мэргэжлийн эмч нартай хамтран хувь хүний нууцыг хадгалах, сайжруулах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж үр дүнг мэдээлэх, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлж ажиллах;

6.2.5.Халдварт өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний шуурхай багийн бэлэн байдлыг хангах, чадавхжуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн нөхцөл байдалтай уялдуулан тодотгож ажиллах;

6.2.6.Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах.

6.3.Өрхийн эрүүл мэндийн төв

6.3.1.Хорооны Засаг даргатай хамтран хүн амын бүртгэлийг насны бүлэг, хүйсийн ангилалаар гаргах, зорилтот бүлэг, насны иргэдийн болон түр оршин суугч иргэн, оюутны мэдээлэл судалгааг жил бүр шинэчлэх;

6.3.2.Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, зөв дадлыг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага, төр, төрийн бус байгууллагатай хамтран тогтмол олон хэлбэрээр зохион байгуулах;

6.3.3.Эрсдэлт бүлгийн болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрүүлжүүлэх;

6.3.4.Нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

6.3.5.Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвд тайлагнах.

6.4.Иргэд, Аж ахуйн нэгж, Байгууллага

6.4.1.Хороо, өрхийн Эрүүл мэндийн төвүүдээс болон бусад эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулж буй эрүүл мэндийн үйл ажиллагаа, сургалт сурталчилгаанд идэвхтэй оролцох;

6.4.2.Иргэд жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

6.4.3.Байгууллагууд албан хаагчдаа жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах;

6.4.4.Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх арга хэмжээг үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран тогтмол явуулах;

6.4.5.Байгууллага бүр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт ажилтнуудад чиглэсэн эрүүл мэндийн арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангах;

6.4.6.50 ба түүнээс дээш ажилтантай байгууллага бүр эмч, сэтгэл зүйчийг хуулийн дагуу ажиллуулах, өрөө тасалгааг тохижуулах;

6.4.7.Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

ДОЛОО. ХАМРАХ ХҮРЭЭ

7.1.Дүүргийн нутгийн захиргааны байгууллага;

- 7.2.Дүүргийн төрийн захиргааны байгууллага, хороод;
- 7.3.Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага;
- 7.4.Дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллага;
- 7.5.Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль;
- 7.6.Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага;
- 7.7.Дүүргийн иргэд;
- 7.8.Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага;
- 7.9.Олон Улсын байгууллага.

НАЙМ.ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

- 8.1.Төслийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:
 - 8.1.1.Дүүргийн төсөв;
 - 8.1.2.Хандивлагч байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, ОУБ, иргэдийн хандив тусламж;
 - 8.1.3.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, төсөл, арга хэмжээний санхүүжилт;
 - 8.1.4.Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.



ЕС.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 9.1.Товлолт дархлаажуулалтын хувь;
- 9.2.Нэмэлт, цагийн шинжтэй дархлаажуулалтын хувь;
- 9.3.Эрт илрүүлэг үзлэгийн тоо;
- 9.4.Хамрагдсан иргэний тоо;
- 9.5.Илрүүлсэн өвчлөл, хувь;
- 9.6.Эрүүлжилт хувь;
- 9.7.Мэдлэг олгох арга хэмжээний тоо, үр дүн, үнэлгээгээр;
- 9.8.Мэдлэг олгосон иргэн, тоогоор тус тус тооцно.

АРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 10.1.Хяналт, үнэлгээг жилд 2 удаа буюу хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хийлгэнэ.
- 10.2.Хөндлөнгийн байгууллагын хяналт, үнэлгээг 2 жил тутамд 1 удаа хийнэ.

---ooOoo---



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг
дэмжих төсөл” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 12 дугаар тогтоолын 2.1.6 дахь хэсгийг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, өвчлөл, эндэгдлийг бууруулах “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шаардагдах төсвийг жил бүр, цаг үеийн нөхцөл байдал, судалгаатай уялдуулан төлөвлөн, баталж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Ц.Баттөр)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо (Х.Эрдэнэтуяа)-нд даалгасугай.

ДАРГА



Б.ЗОЛБОО

1925030014

Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 23 дугаар сарын 27-ны
өдрийн 29 дугаар тогтоолын хавсралт



ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-д “Судалгаа, нотолгоонд суурилсан хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй бодлого, хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх, Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэж тусгасан.

Шалгуур үзүүлэлтийг:

1.1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин

2.100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшингээр үнэлэхээр тусгасан.

Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дох хэсэг “Хүний хөгжлийн бодлого” арга хэмжээнд:

2.1.1.Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.1.4.Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна гэж тусгасан.

Төслийн хэрэгцээ шаардлага

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нь тухайн байгууллагын үйлчилгээнээс гадна өвчний эдгэрэл, онцлогтой уялдсан хийсвэр хүчин зүйлс болон чанарын үзүүлэлтийн нөлөө ихтэйгээрээ бусад салбараас онцлог байдаг. Дэлхийд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сэтгэл ханамжийг тодорхойлохдоо тусламж, үйлчилгээний юу нь таалагдаж, эсвэл юу нь үл таалагдаж байгаа талаар хэрэглэгчдийн судалгаа, хувь хүн ямар үйлчилгээний төлөө үнэ төлөх хүсэлтэй байгааг тогтоох замаар судлах аргуудыг түлхүү санал болгодог. Эдгээр нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, сайжруулах арга замын талаарх нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангах үнэтэй чиг баримжааг бий болгодог.

Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлага, ёс зүй, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь нэн тэргүүний асуудал бөгөөд үйл ажиллагааг үр дүнд суурилсан, чанартай хэрэгжүүлэхэд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж чухал юм. Иймээс эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгч жирэмсэн эмэгтэйчүүд, 0-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамжийг судалж нотолгоонд тулгуурласан арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор 2020 онд Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүүхдийн сан энэхүү судалгааг гүйцэтгэсэн байна. (11-12х)

Судалгаанд Улаанбаатар хотын БЗД-ийн 13 хороо, СХД-ийн 16 хороо, Баянхонгор аймгийн 6 багын 16-45 насны 958 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь 25-34 насны, дээд боловсролтой, гэр хороололд амьдардаг. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 91.2 хувь нь өрхийн Эрүүл мэндийн төвөөс жирэмсний хяналттай холбоотой зөвлөгөө тусламж үйлчилгээ авсан байна.

Эмч, эмнэлгийн ажилчид жирэмсний хяналттай холбоотой дараах зөвлөгөөг жирэмсэн эмэгтэйчүүдэд өгсөн байна. Үүнд:

- 91.1 хувь (95%ИХ: 87.9-93.6) хяналтад хэрхэн орох;
- 66.5 хувь (95%ИХ: 58.1-73.9) нь БЗДХ-аас сэргийлэх;
- 67.6 хувь (95%ИХ: 60.3-74.1) нь жирэмсний явцад архи, тамхины хэрэглээ хортой нөлөө үзүүлэх зэрэг зөвлөгөөг өгсөн байв.


Жирэмсэн эмэгтэйчүүдэд БЗДХ-аас сэргийлэх, жирэмсний үеийн хооллолт, хорт зуршлын нөлөөллөөс сэргийлэх зөвлөгөө өгсөн байдал Баянхонгор аймагт статистикийн ач холбогдол бүхий ялгаатай илүү зөвлөгөө тусламжийг үзүүлсэн байна. (Зураг 2)

Нийт судалгаанд оролцогчдын 87.1 хувь (95%ИХ 80.7-91.7) нь өрхийн эрүүл мэндийн төвөөс жирэмсний хяналттай холбоотой ямар нэг үйлчилгээг авсан, 92.2 хувь нь үзлэг, эмчилгээ хийлгэсэн байна. (Зураг 3)


Баянхонгор аймгийн жирэмсэн эмэгтэйчүүдийн ӨЭМТ-өөс жирэмсний хяналттай холбоотой тусламж үйлчилгээг авсан байдал статистикийн ач холбогдол бүхий өндөр байлаа. (Зураг 4)



Зураг 2. Өрхийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүдийн үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгсөн байдал



Зураг 3. Жирэмсэн эмэгтэйчүүдийн ӨЭМТ-өөс авсан тусламж үйлчилгээ, (судалгаанд хамрагдсан газраар)



Зураг 4. Өрхийн эрүүл мэндийн төвөөс жирэмсний хяналттай холбоотой тусламж үйлчилгээ авсан байдал (үйлчилгээний төрлөөр)

Судалгааны ерөнхий дүгнэлтэд:

-Өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг болон дүүргийн Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгч жирэмсэн эмэгтэй, 0-5 насны хүүхдийн асран хамгаалагчид байршлаас хамаарахгүй эрүүл мэндийн үйлчилгээ, үйл ажиллагаа, орчин нөхцөлд сэтгэл хангалуун байна;

-БЗД-ийн жирэмсэн эмэгтэйчүүд эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн өрөө, автомашины зогсоолд, СХД-ийн жирэмсэн эмэгтэйчүүд дүүргийн Эрүүл мэндийн төвийн автомашины зогсоолд “сэтгэл дундуур” байна.

Энэ нь үйлчлүүлэгч эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн өрөө, автомашины зогсоолд сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд цаашид үйлчилгээг илүү сайжруулах арга хэмжээ авахыг шаардаж байгааг илэрхийлсэн гэж дурьдсан байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд:

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд нь олон янз бөгөөд орон нутгийн онцлогоос, нийгмийн орчин, хөгжил дэвшил зэргээс хамааралтай байдаг.

Гэхдээ дэлхий даяар түгээмэл тулгамдсан зарим асуудлыг дараах байдлаар тодорхойлсон байна:

1. Эрүүл мэндийн боловсрол хангалтгүй: Залуучууд, тэр дундаа өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэггүй байдал олон асуудал үүсгэж байна. Тухайлбал, бэлгийн харилцааны хамгаалалтгүй байх нь бэлгийн замын халдварт өвчин, жирэмслэлтээс сэргийлэх асуудалтай холбоотой;

2. Жирэмслэлтээс сэргийлэх аргын мэдлэг дутмаг: Зарим бүс нутагт болон хөгжиж буй орнуудад жирэмслэлтээс сэргийлэх хэрэгслийг олж авахад хүндрэлтэй байдаг. Энэ нь төлөвлөлтгүй жирэмслэлт, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх шалтгаан болдог;

3. Бэлгийн замын халдварт өвчин: Бэлгийн замаар дамжих халдварт өвчнүүд (ЖДХӨ) нь дэлхий даяар өсөж буй асуудал юм. Бэлгийн харилцааны хамгаалалтгүй байдал, хуучин мэдээллийн систем зэрэг нь энэ асуудлыг хурцатгаж байна;

4. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхтний өвчнүүд: Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, тухайлбал, умайн хүзүүний хавдар, хавдрын эрт илрүүлэлт, хатуу хөхний өвчин зэрэг нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд ихээхэн нөлөөлдөг;

5. Мэдрэлийн болон сэтгэл зүйн асуудлууд: Жирэмслэлт, төрөх, хүүхэд асрахтай холбоотой сэтгэл зүйн болон мэдрэлийн асуудлууд (жишээ нь, төрөхийн дараах депресс, сэтгэл санааны дарамт) нь мөн эрүүл мэндийн нэг чухал асуудал юм;

6.Жендэрийн болон соёлын хязгаарлалт: Зарим соёл, улс орнуудад эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалтай холбоотой эрх чөлөө, мэдлэг олгох асуудал байдаг. Тухайлбал, хүүхдийн төрсөн дараах төрийн тусламж үйлчилгээ, эмчилгээ авах эрхийн хязгаарлалтууд.

Эдгээр асуудал нь зөвхөн эмэгтэйчүүд төдийгүй эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд ч нөлөөлж байдаг. Үүнтэй тэмцэхийн тулд холбогдох мэдлэг, боловсрол олгох, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлагатай.

Эх, хүүхдийн эрүүл мэнд:

Монгол Улс дахь эхийн эндэгдлийн гол шалтгаан нь төрөлт болон жирэмслэлтийн үеийн хүндрэлүүдтэй холбоотой байдаг. Эдгээр шалтгаануудын зарим нь:

-Төрөлтийн үеийн хүндрэл: Хэт их цус алдалт, умайн хүзүүний хавдар, гүйцэд биш төрөлт, төрсний дараах хүндрэлүүд нь эхийн нас баралтын шалтгаан болж байна.

-Жирэмслэлтийн үеийн хүндрэл: Жирэмсний өндөр даралт, чихрийн шижингийн өвчин, зүрх судас болон бөөрний өвчлөл зэрэг жирэмслэлттэй холбоотой өвчнүүд нь эхийн эндэгдэлд хүргэж байна.

-Эмнэлгийн үйлчилгээний хомсдол: Хөдөө орон нутагт, эмнэлгийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн дутагдал, эмч, сувилагчдын хүрэлцээ муу байдал, мэдлэгийн дутагдал зэрэг нь эхийн эндэгдлийг нэмэгдүүлдэг.

-Төрөх үйлчилгээний чанар: Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эмнэлгийн багаж хэрэгсэл, мөн мэргэжилтнүүдийн туршлага, ур чадвар муу байх нь эхийн эндэгдлийн гол шалтгаануудын нэг юм.

Эхийн эндэгдлийн статистик:

Монгол Улс дахь эхийн эндэгдэл сүүлийн жилүүдэд буурч байгаа хэдий ч, өндөр хэвээр байгаа.

Эрүүл Мэндийн Яам болон ДЭМБ-ийн мэдээллээр:

Монгол Улс дахь эхийн эндэгдлийн түвшин сүүлийн жилүүдэд буурч байгаа ч 2020 онд эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд 20 байсан.

Сүүлийн 10 жилд эхийн эндэгдлийн түвшин буурсан ч 2010 оны эхэн үед харьцангуй өндөр байсан энэ үзүүлэлт сүүлийн 10 жилд хурдацтай буурч, 2021 оны эхээр 100,000 амьд төрөлтөд 10 орчим болсон байна.

Иймд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл”-ийг боловсруулаад байна.

ХОЁР.ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, жирэмслэлт болон төрөхийн үеийн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй болгож, эх, хүүхдийн эндэгдэл, өвчлөлийг бууруулахад оршино.

ГУРАВ.ТӨСЛИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

3.1.Зорилт 1

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, боловсролыг нэмэгдүүлэх, хувь хүн, гэр бүл, олон нийтэд

сурталчлан таниулах олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, гэр бүл төлөвлөлтийг сайжруулах.

3.1.1.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1.1.Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;

3.1.1.2.Зорилтот бүлэг болон нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, гэр бүл төлөвлөлтийг сайжруулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

3.1.1.3.Эрүүл мэндийн байгууллагын эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний кабинетын үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, мэдээллийн өрөөтэй болох.

3.1.2.Хүрэх үр дүн:

3.1.2.1.Нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлтийн асуудал сайжирч, ЖСА хэрэглээ нэмэгдсэн байна. (Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт буурсан байна).

3.2.Зорилт 2

Өсвөр насныханд бие махбодын хөгжил, жирэмслэлт, гэр бүл төлөвлөлт, бэлгийн харилцааны эрүүл дадал, хамгаалалттай бэлгийн харилцааны талаар зөв мэдээлэл олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, тэдэнд зориулсан кабинеттай болох.

3.2.1.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1.1.Өсвөр насныханд зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

3.2.1.2.Өсвөр насныханд зориулсан олон нийтийн сүлжээний судалгааг хийх, мэдээлэл, сурталчилгааг боловсруулах, цахим хичээл, зөвлөгөөний сайтыг нээн ажиллуулах, хөгжүүлэх;

3.2.1.3.Эрүүл мэндийн байгууллагуудад өсвөр үеийнхэнд зориулсан кабинет байгуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулах.

3.2.2.Хүрэх үр дүн:

3.1.2.2.Өсвөр үеийнхэнд зориулсан кабинеттай болж, жирэмслэлт буурсан байна. (11-16 насны);

3.1.2.2.Эрүүл мэндийн боловсрол нэмэгдсэн байна.

3.3.Зорилт 3

Эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, жирэмслэлт, төрөлт, төрсний дараах эх, нярайн эрүүл мэндийг дэмжих, өвчлөл, эндэгдлийг бууруулах.

3.3.1.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1.1.Жирэмсэн болон төрсөн эх, нярайд зориулсан эрүүл мэндийн хяналтыг системтэйгээр явуулах, хяналтын үйл ажиллагаанд төрийн, төрийн бус байгууллага болон иргэдийн оролцоог хангаж жирэмслэлтийн үеийн эрсдэлээс сэргийлэх;

3.3.1.2.Жирэмсэн эмэгтэйчүүдийн хоолны дэглэмийг сайжруулах, эрүүл ахуйн зөвлөгөө өгч, эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах, зөв хооллох аргад сургах;

3.3.1.3.Төрсний дараах тусламж үйлчилгээ, гэрийн эргэлт, нярайн эрсдэлийг үнэлэх аргад эмч, мэргэжилтнүүдийг, хүүхдийн амьсгал, зүрхний цохилт,



температур, жин, өндөр зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг гэрийн нөхцөлд хянах аргад эцэг, эх, асран хамгаалагчдыг сургах;

3.3.1.4.Төрсний дараах сэтгэл зүйн төлөв байдал, сэтгэл санааны байдал, стресс болон төрөлттэй холбоотой сэтгэлзүйн өөрчлөлтүүдийг зөв удирдах аргад эмэгтэйчүүдийг сургах;

3.3.2. Хүрэх үр дүн:

3.3.2.1.Жирэмслэлтийн хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирснаар эхийн амь насанд аюул учрах эрсдэл буурна;

3.3.2.2.Жирэмсний хяналт сайжирснаар ургийн гажиг, эрт нярайн эндэгдэл буурсан байна;

3.3.2.3.Эхийн хэвийн хооллолт, зөв хооллолт хүүхдийн төрсний дараах эрүүл мэндийг дэмжсэн, өвчлөлийг бууруулсан байна.



ДӨРӨВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Төслийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

ТАВ.ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

5.1.Төслийн зардлыг бүрэн тооцож, жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1.Орон нутгийн төсөв;

5.1.2.Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр;

5.1.3.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4.Бусад эх үүсвэр.

ЗУРГАА.ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

6.1.Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх;

6.2.Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;

6.3.Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх;

6.4.Дүүргийн хүн ам, нийгэм, эдийн засгийн байдал, орчны нөхцөл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээ онцлогийг харгалзсан байх.

ДОЛОО.ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар

7.1.1.Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

7.1.2.Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг жил бүрийн дүүргийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.3.Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын зөвлөлд, жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл, Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо, хуралдаанд тайлагнах;

7.1.4. Байгууллага хоорондын уялдаа холбоог хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

7.2. Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг

7.2.1. Эрүүл мэндийн төв нь өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.2.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дахь сургалтыг тасралтгүй явуулах;

7.2.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, цахим бүртгэлийн сантай болгож, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг холбогдох дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

7.2.5. Эх, хүүхдийн эндэгдлийн дүгнэлтийг тухай бүрт хийж, алдаа зөрчлийг илрүүлэн засаж, хэлэлцэж, нас баралт, өвчлөлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах, сайжруулах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж үр дүнг мэдээлэх, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлж ажиллах;

7.2.6. Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах.

7.3. Өрхийн Эрүүл мэндийн төв, хорооны Засаг дарга

7.3.1. Хорооны Засаг даргатай хамтран хүн амын бүртгэлийг насны бүлэг, хүйсийн ангиллаар гаргах, зорилтот бүлэг, насны иргэдийн болон түр оршин суугч иргэн, оюутны мэдээлэл судалгааг жил бүр шинэчлэх;

7.3.2. Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, зөв дадлыг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага, төр, төрийн бус байгууллагатай хамтран тогтмол олон хэлбэрээр зохион байгуулах;

7.3.3. Эрсдэлт бүлгийн болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрүүлжүүлэх;

7.3.4. Нөхөн үржихүйн насны хүн амын дундах зонхилон тохиолдох өвчлөлийн тандалт, судалгааг зохион байгуулж, хариу арга хэмжээг төлөвлөх;

7.3.5. Нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

7.3.6. Төслийн үр дүнг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төвд тайлагнах.

7.4. Иргэд, Аж ахуйн нэгж, Байгууллага

7.4.1. Хороо, өрхийн Эрүүл мэндийн төвүүдээс болон бусад эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулж буй эрүүл мэндийн үйл ажиллагаа, сургалт сурталчилгаанд идэвхтэй оролцох;

7.4.2. Иргэд жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

7.4.3. Байгууллагууд албан хаагчдаа жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах;

7.4.4. Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх арга хэмжээг үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран тогтмол явуулах;

7.4.5. Байгууллага бүр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт ажилтнуудад чиглэсэн эрүүл мэндийн арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангах;



7.4.6.50 ба түүнээс дээш ажилтантай байгууллага бүр эмч, сэтгэл зүйчийг хуулийн дагуу ажиллуулах, өрөө тасалгааг тохижуулах;

7.4.7.Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг хагас жил тутам дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах.

НАЙМ.ТӨСЛИЙН ШАЛГУУР

- 8.1.Сэтгэцийн эрүүл мэндийн талаар мэдээлэл авсан хүмүүсийн тоо;
- 8.2.Эмчилгээ, үйлчилгээ авах хүсэлт гаргасан иргэдийн тоо;
- 8.3.Нийгэм, иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн талаарх сөрөг ойлголт буурсан тоо;
- 8.4.Хамт олны дэмжлэгтэйгээр сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн тоо;
- 8.5.Төсөл нь нийгмийн сайн сайхны төлөө, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоо хангасан, нийгмийн бүх давхаргад хүртээмжтэй хүрсэн тоо.



ЕС.ХАМРАХ ХҮРЭЭ

- 9.1.Дүүргийн нутгийн захиргааны байгууллага;
- 9.2.Дүүргийн төрийн захиргааны байгууллага, хороод;
- 9.3.Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага;
- 9.4.Дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллага;
- 9.5.Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль;
- 9.6.Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага;
- 9.7.Дүүргийн иргэд;
- 9.8.Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага;
- 9.9.Олон Улсын байгууллага.

АРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 10.1.Хяналт, үнэлгээг жилд 2 удаа буюу хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хийлгэнэ.
- 10.2.Хөндлөнгийн байгууллагын хяналт, үнэлгээг 2 жил тутамд 1 удаа хийнэ.

---ooOoo---

**ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ
ТӨСЛИЙН 2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго:

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, жирэмслэлт болон төрөхийн үеийн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй болгож, эх, хүүхдийн эндэгдэл, өвчлөлийг бууруулахад оршино.

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Түвшин		Хугацаа	Хариуцах эзэн
				Суурь 2024	Хүрэх 2028		
ЗОРИЛТ 1: Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, боловсролыг нэмэгдүүлэх, хувь хүн, гэр бүл, олон нийтэд сурталчилан таниулах олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, гэр бүл төлөвлөлтийг сайжруулах.							
1.1. Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах;							
1	Сургалт арга хэмжээ зохион байгуулах;	150,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувмар	96	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
2	Нөхөн үржихүйн насны хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг (эрэгтэйчүүдийн үзлэг, зөвлөгөө) нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулах;	120,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувмар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
3	Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах (ургийн ЭХО аппарат, лабораторийн шинжилгээний аппарат);	1,000,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Эрүүл мэндийн байгууллагад олгох тоног, төхөөрөмж, тоо	26	4	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
4	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг ургийн монитороор хангах ажлыг зохион байгуулах.	260,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Эрүүл мэндийн байгууллагад олгох тоног, төхөөрөмж, тоо	26	26	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
1.2. Зорилтот бүлэг болон нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;							

1	Нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулах.	57,0 сая Дүүргийн ЗДУАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ, хороо
1.3. Эрүүл мэндийн байгууллагын эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, мэдээллийн өрөөтэй болох.							
1	Эрүүл мэндийн байгууллагын эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, мэдээллийн өрөөтэй болох.	50,0 сая Дүүргийн ЗДУАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
ЗОРИЛТ 2: Өсвөр насныханд бие махбодийн хөгжил, жирэмслэлт, гэр бүл төлөвлөлт, бэлгийн харилцааны эрүүл дадал, хамгаалалттай бэлгийн харилцааны талаар зөв мэдээлэл олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, тэдэнд зориулсан кабинеттай болох.							
2.1. Өсвөр насныханд зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;							
1	Өсвөр насныханд бие махбодийн хөгжил, жирэмслэлт, гэр бүл төлөвлөлт, бэлгийн харилцааны эрүүл дадал олгох сургалтыг сургуулийн нийгмийн ажилтан, эмч, эцэгийн оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах	20,0 сая Дүүргийн ЗДУАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ, хороо
2.2. Өсвөр насныханд зориулсан олон нийтийн сүлжээний мэдээлэл, сурталчилгааг боловсруулах, цахим хичээл, зөвлөгөөний сайтыг нээн ажиллуулах, хөгжүүлэх;							
1	Өсвөр насныханд зориулсан олон нийтийн сүлжээний мэдээлэл, сурталчилгааг боловсруулах, цахим хичээл, зөвлөгөөний сайтыг нээн ажиллуулах, хөгжүүлэх.	24,0 сая Дүүргийн ЗДУАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, БХ, ӨЭМТ, ЕБС
2.3. Эрүүл мэндийн байгууллагуудад өсвөр үеийнхэнд зориулсан кабинет байгуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр бий болгох.							
1	Өсвөр үеийн кабинет байгуулах тусгай арга хэмжээний төсөл боловсруулах, төрийн бус олон улсын байгууллагад хүргэх, танилцуулах, дэмжлэг авах ажлыг зохион байгуулах	100,0 сая Дүүргийн ЗДУАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, БХ, ӨЭМТ, ЕБС
ЗОРИЛТ 3: Эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, жирэмслэлт, төрөлт, төрсний дараах эх, нярайн эрүүл мэндийг дэмжиж, өвчлөл, эндэгдлийг бууруулах.							
3.1. Эх, нярайд зориулсан эрүүл мэндийн хяналтыг системтэйгээр явуулж, жирэмслэлтийн үеийн эрсдэлээс сэргийлэх;							

1	9-11 долоо хоногтой хяналтын үзлэг, оношлогоог эрчимжүүлэх, урвалжаар хангах, эрсдэлтэй жирэмсэн эхчүүдийг хамруулах /TORCH, PCR/.	420,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Хангах урвалж, тоо	0	54,000	2025-2028	ЭМТ, НЭ, ӨЭМТ
3.2.Жирэмсэн эмэгтэйчүүдийн хоолны дэглэмийг сайжруулах, эрүүл ахуйн зөвлөгөө өгч, эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах, зөв хооллох аргад сургах;							
1	Жирэмсэн эмэгтэйчүүдийн хоолны дэглэмийг сайжруулах, зөв хооллох аргад сургах цахим сайтыг хөгжүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	18,0 Дүүргийн ЗДҮАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
3.3.Төрсний дараах сэтгэл зүйн төлөв байдал, сэтгэл санааны байдал, стресс болон төрөлттэй холбоотой өөрчлөлтүүдийг зөв удирдах аргад эмэгтэйчүүдийг сургах.							
1	Сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, төрсний дараах депресс, стрессийн эрсдэлээс сэргийлэх аргад эмэгтэйчүүдийг сургах сургалтыг зохион байгуулах;	20,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ЭМТ, НЭ, ӨЭМТ
2	Гэр бүлүүдэд зориулсан стрейссыг удирдах, даван туулах, төрөлттэй холбоотой сэтгэлзүйн өөрчлөлтүүдийг зөв удирдах цахим хичээлийг боловсруулан олон нийтэд сурталчлах.	60,0 сая Дүүргийн ЗДҮАХ зардал	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	95	100	2025-2028	ЗДТГ, НХХ, ХМОНХТ ЭМТ, НЭ, ӨЭМТ
2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ТОО							13 АРГА ХЭМЖЭЭ
2025-2028 ОНД ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ							2,299,0 САЯ ТӨГРӨГ



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

“Иргэдийн Соёлын боловсролыг дээшлүүлэх”
төсөл-2”-ыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15.1.1 дэх заалт, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 12 дугаар тогтоолын 2.5 дахь заалтыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэдийг соён гэгээрүүлэх, соёл урлагаар дамжуулан хөгжүүлэх, нийгмийн харилцаанд тэгш оролцуулах, соёлын ойлголтуудыг өргөжүүлж, тэднийг эерэг өөрчлөлтөд хүргэх зорилго бүхий “Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл-2”-ыг хавсралтаар баталсугай.

2.Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шаардагдах төсвийг жил бүр, цаг үеийн нөхцөл байдал, судалгаатай уялдуулан төлөвлөн, баталж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Ц.Баттөр)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо (Х.Эрдэнэтуяа)-нд даалгасугай.

ДАРГА



Б.ЗОЛБОО

1925030016

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Жаргалант тосгоны соёлын ордон, Улсын Хүүхэд Залуучуудын театр, Улаанбаатар төв номын сангийн харьяа Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан, 2, 8, 15 дугаар хорооны бичил номын сан, Соёмбо кино театр, интернет, караоке, цэнгээнт үйлчилгээний газрууд нь дүүргийн нийт 330000 гаруй иргэнд үйлчилж байна.

Дүүргийн Соёлын ордон нь хотын төвөөс алслагдмал бөгөөд мэргэжлийн багш боловсон хүчин, техник тоног төхөөрөмжийн нөөц бололцоондоо тулгуурлан соёл, урлагийн олон талт үйл ажиллагаа явуулдаг боловч хязгаарлагдмал, мөн стандартад нийцсэн 750 хүний суудалтай Улсын Хүүхэд, залуучуудын театр ашиглалтад орсон хэдий ч яамны харьяа тул соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулах боломж нөхцөлөөр хомс байна.

2020 оны 7, 8 дугаар сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Соёл, урлагийн газар болон Шинжлэх ухаан технологийн их сургуулиуд хамтран “Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалын бүртгэл судалгаа” төслийг хэрэгжүүлж, төслийн хүрээнд Улаанбаатар хот орчимд хийсэн археологийн судалгаагаар Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт түүх, соёлын дурсгалт 68 газрын 324 дурсгал бүртгэгдсэн.

Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын хувьд одоогоос 3000-3500 жилийн тэртээх үетэй холбогдох Хүннү, Хүрэл зэрэг Монголын эртний нүүдэлчдийн соёлын биет өв болох булш, хиргисүүрийн газар, дурсгалууд нь эрсдэлийн 1-р төвшинд буюу эрсдэлгүй-0, 2-р төвшинд буюу бага эрсдэлтэй-8 газрын 22 дурсгал, 3-р төвшинд буюу дунд эрсдэлтэй-19 газрын 70 дурсгал, 4-р төвшинд буюу өндөр эрсдэлтэй-41 газрын 232 дурсгал байна.

14 хөшөө дурсгал, 16 булш хиргисүүрийн 185 дурсгалыг кадастржуулж, газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх, хамгаалалтын бүс тогтоох ажлыг Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны Археологийн хүрээлэн, Газар зохион байгуулалтын 1, 2 дугаар албаны мэргэжлийн багтай хамтран хийж хэрэгжүүлсэн.

Соёлын биет бус өв нь аливаа үндэстэн, угсаатны бүлэг, хамт олны оршин тогтнох, сэтгэх, бүтээж туурвих, амьдран хөгжих эх ундарга, амьдралын өвөрмөц төрх, зан үйл, хөгжил дэвшлийнх нь нэгэн илэрхийлэл болж, өргөн утгаараа тухайн улс, үндэстний үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж байдаг учраас соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах, дэмжих талаар дэлхий нийтээр ихээхэн анхаарч байна. Уламжлалт соёлоо хадгалж хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх, судалж сурталчлах талаар бодлогын баримт бичгүүд нэлээдгүй чиглэж байна.

Дүүргийн соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын 2024 оны бүртгэлээр 7 ай савын 330 өвлөн уламжлагч баталгаажиж мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Цаашид Соёлын биет бус өвийн 7 ай савын 362 төрлөөр авах судалгааг нарийвчлан, мэргэжлийн төвшинд гаргаж, улирал тутам бүртгэлийг шинэчлэн баяжуулах ажлыг тогтмолжуулах, цахим системд бүртгэл зэрэг ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Энэхүү ажлыг чанаржуулах зорилгоор мэдээллийн технологийг ашиглан өв тээгч бүрийг соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн “jch.mongoluv.mn” програмд шивж оруулах, судалгаа, бүртгэл мэдээллийг чанаржуулах ажлыг зохион байгуулахад орон нутгийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай.

Түүнчлэн соёлын биет бус өвийн ай савын өвийг тээгч, өвлөн уламжлагчдыг илрүүлэх, тэднийг дэмжих, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, сурталчлах, үндэсний болон нийслэл, дүүргийн өвд бүртгэгдэх өвлөгчийн тоог нэмэгдүүлэхэд тодорхой ажлууд дутмаг байна.

Мөн Соёлын үйлчилгээ эрхлэгчдэд үйлчилгээний байгууллагын чанар стандартыг мөрдүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэхэд дэмжих, мөн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, зөрчлийг арилгуулах зэрэг ажлыг зохион байгуулах нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулна.

Иймд иргэдийнхээ оюуны суурь дархлаа болох соёлын боловсролыг дээшлүүлэх, уламжлагдан ирсэн өв соёлоо хамгаалан өвлүүлэх, соёлын дэвшилтэд хөгжилтэй хөл нийлүүлэн алхах чадвартай оюунлаг, хүмүүнлэг, соёлтой иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү төслийг боловсрууллаа.

ХОЁР.ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1.Төслийн зорилго

Соёлын боловсрол буюу үндэсний болон хүн төрөлхтний соёлын дээжээс хүртэх, соёлын үнэт зүйлсийг эзэмших, соёлын цогц чадамжтай болох, соёлын үнэ цэнийг ойлгох, хүндэтгэх, түгээх, өвлүүлэх, хөгжүүлэх, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, иргэдийн оролцоотойгоор уламжлагдан ирсэн өв соёл, үнэт зүйлээ хамгаалах, өвлүүлэх, сурталчлан таниулах, баяжуулах ажлыг шат дараатай зохион байгуулж, соёлын дэвшилтэд хөгжилтэй хөл нийлүүлэн алхах чадвартай оюунлаг, хүмүүнлэг, соёлтой иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино.

2.2.Төслийн зорилт

2.2.1.Иргэд, байгууллагын соёлын боловсролын хүрээг нэмэгдүүлнэ;

2.2.2.Соёлын орон зай бүхий соёл, урлагийн үйлчилгээтэй төвийг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлнэ;

2.2.2.Өв соёл, уламжлал, үнэт зүйлээ хамгаалж, өвлүүлэх, сурталчлан таниулж, баяжуулна.

ГУРАВ.ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Төслийг хэрэгжүүлэх үе шат

3.1.1.Нэгдүгээр үе шат 2025 он /төслийг боловсруулж, батлуулах/;

3.1.2.Хоёрдугаар үе шат 2025-2028 он /хэрэгжүүлэн хэвшүүлж, үр дүнг тооцох/.

ДӨРӨВ.ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1."Иргэд, байгууллагын соёлын боловсролын хүрээг нэмэгдүүлнэ" нэгдүгээр зорилтын хүрээнд:

4.1.1.Бүх шатны боловсролын байгууллага, олон нийтийн байгууллагаар дамжуулан хүүхдийг бага наснаас нь танин мэдэхүй, хийж бүтээх, хамтдаа амьдрах, хүн байх соёлд суралцуулах ажлыг зохион байгуулна;

4.1.2.Иргэд, байгууллагын соёлын боловсролыг дээшлүүлэх, хотын соёлыг хэвшүүлэх дадлыг бий болгох чиглэлээр олон талт ажлыг зохион байгуулах;

4.1.3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим соёлын хүрээнд биет бус өв тээгч, биет өвүүдийг таниулах, иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.

4.2."Соёлын орон зай бүхий соёл, урлагийн үйлчилгээтэй төвийг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлнэ" хоёрдугаар зорилтын хүрээнд:

4.2.1.Хүүхэд, залуучууд, ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт олон төрлийн бүлгүүдэд сургалт, боловсролын хөтөлбөрүүд, хөгжиж буй ур чадваруудыг дэмжих үйл ажиллагаа, спорт, соёлын арга хэмжээнүүд зохион байгуулах.

4.3."Өв соёл, уламжлал, үнэт зүйлээ хамгаалж, өвлүүлэх, сурталчлан алдаршуулах, хөгжүүлэх" хоёрдугаар зорилтын хүрээнд:

4.3.1.Түүх, соёлын үл хөдлөх, хөдлөх хөшөө дурсгал болон археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

4.3.2.Биет бус өвийн ай савын өвлөн уламжлагчдын бүртгэлийн мэдээллийн санг баяжуулан, тэднийг алдаршуулахад зориулсан наадам, өдөрлөг, уулзалтаар дамжуулан өв соёл, уламжлалаа дээдэлдэг иргэдийг төлөвшүүлэхэд дэмжих.

ТАВ.ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1.Төслийн үр нөлөө

5.1.1.Тогтвортой хөгжлийн суурь дархлаа болох иргэдийн соёлын боловсролыг дэмжсэн шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулагдаж үр дүнгээ тооцсон байна;

5.1.2.Соёл, урлагийн үйлчилгээг бүх нас, бүлгийн хүмүүст зориулсан үйл ажиллагаа илүү хүртээмжтэй, олон нийтэд нээлттэй болгож, бүх насны, бүх бүлгийн хүмүүст нээлттэй орон зайг бий болгосноор нийгмийн бүх хэсэгт тэгш боломж олгож, нийгмийн тэгш байдлыг нэмэгдүүлнэ.Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орон нутгийн иргэд, ахмад настнууд гэх мэт бүлгүүдийг хамруулан, соёлын үйлчилгээг илүү хүртээмжтэй болгоно;

5.1.3.Өв соёл, уламжлал, үнэт зүйлээ хамгаалж, өвлүүлэх, сурталчлах ажлаар дамжуулан өв соёл, уламжлалаа дээдэлдэг иргэдийг төлөвшүүлсэн байна.

ЗУРГАА.ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

6.1.Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

6.1.1.Дүүргийн төсөв;

6.1.2.Хандив дэмжлэг;

6.1.3.Төсөл хөтөлбөр;

6.1.4.Бусад эх үүсвэр.

ДОЛОО.ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1.Төслийн хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Жаргалант тосгоны Соёлын ордон хамтран зохион байгуулж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.



---ooOoo--